

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

#### Нэгжийн нэр:

Алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллага

#### Албан тушаалын нэр:

Харуулын цагдаа

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан  
цагдаагийн байгууллагын байр.

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын харуул, хамгаалалтын үүргийг хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд дэмжлэг үзүүлэх.

#### Албан тушаалын зорилт:

1.Монгол Улсын Засгийн газраас цагдаагийн байгууллагын хамгаалалтад байхаар тогтоосон Улсын онц чухал объект, шүүхийн барилга, байгууламж, олон улсын гэрээгээр тогтоосон гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам болон Консулын газар, Нэгдсэн үндэсний байгууллагын суурин төлөөлөгчийн газар, хэн өмчилж байгаагаас үл шалтгаалан төлөөлөгчийн газрын тэргүүний өргөө, төлөөлөгчийн газрын зорилгод ашиглаж байгаа барилгын хэсэг, газрыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх.

2.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд дэмжлэг үзүүлэх.

3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлж, удирдлагаас өгсөн үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулах.

| Зорилт                    | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг   | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт       | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах –Т,<br>Харилцан, гүйцэтгэх-Г<br>Хянах-Х<br>Шийдвэрлэх-Ш |
|---------------------------|--|-------------------------------------|--|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <p>1.1.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, тасгийн дарга/түүнтэй адилтгах албан тушаалтан/-ын шийдвэрээр байнгын болон түр харуулын үүрэг гүйцэтгэх.</p> <p>1.2.Батлагдсан харуулын томилгоо, аюулгүй ажиллагааны заавартай танилцаж, баталгаажуулж үүрэг гүйцэтгэх.</p> <p>1.3.Объектын хамгаалалтын талаар мэдлэг чадвартай байж, хяналт тавих цэг, явах чиглэл, орчны нөхцөл байдлыг судлах.</p> <p>1.4 Цагдаагийн дүрэмт хувцсыг зохих журмын дагуу цэвэр үзэмжтэй хэрэглэн цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, эргүүл, харуулын дүрэм, үйл ажиллагааны журмыг мөрдөж, сонор сэрэмж, сахилга, ёс зүйг сахиж, объектыг тасралтгүй хамгаалж, тогтоосон дэглэм журмыг сахиулж, гадны халдлага, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авах.</p> <p>1.5.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох, баривчлах, бусдын болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан үед хамгаалах зорилгоор хэрэглэх, ашиглах.</p> <p>1.6.Объектын цагийн байдлын мэдээллийг цуглуулж, судлан үнэлж, гадна, дотор талын байрлалын орчны нөхцөл байдалд байнгын ажиглалт хийж шууд удирдлагадаа мэдээллэх.</p> <p>1.7.Иргэн, албан тушаалтантай хүндэтгэлтэй харьцаж, объектын захиргаа болон харилцан ажиллагаатай бусад байгууллагатай хамтран ажиллах.</p> <p>1.8.Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулашгүй ажиллагааг хууль, журамд заасан үндэслэлээр явуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлэх.</p> <p>1.9. Объектод нэвтрэх хүн тээврийн хэрэгслийг тогтоосон журмын дагуу шалган нэвтрүүлэх, хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгслийг орох, гарах</p> | Харуул, хамгаалалт бүрэн хэрэгжинэ. | Г<br>Г<br>Г<br>Г<br>Г<br>Г<br>Г<br>Г   |

|                           |  |   |             |
|---------------------------|--|---|-------------|
|                           | <p>боломжоор хангах зорилгоор гарцыг чөлөөлөх.</p> <p>1.10 Зайлшгүй шаардлагатай тохиолдол буюу хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулж болзошгүй гэх зэрэг ноцтой нөхцөл байдал үүссэн бол учирч болох хор хохиролыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор объектыг түр хугацаагаар орхиж, энэ талаар шууд удирдлах албан тушаалтанд мэдэгдэж, объектын хяналтыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авах.</p> <p>1.11. Үүрэг гүйцэтгэх үед гарсан нөхцөл байдлын рапорт, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, эд, аж ахуй хүлээлцсэн тэмдэглэл, хяналт шалгалт, хамгаалалтад илрүүлж, шийдвэрлэн зөрлийн мэдээний бүртгэлийг тус тус хөтлөх.</p> <p>1.12. Нөхцөл байдлын мэдээг цаг тутам, эрх бүхий албан тушаалтанд шалгуулсан талаарх мэдээллийг тэр даруй хариуцлагатай жижүүрт мэдэгдэх.</p> <p>1.13. Шүүх, шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, журамд зааснаар хэрэгжүүлэх.</p> |   | Г           |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>2.1. Хууль, тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, хөтөлбөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.</p> <p>2.2. Гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, албанаас зохион байгуулсан мэргэжлийн сургалт, соён гэгээрүүлэх ажил арга хэмжээнд идэвхитэй хамрагдах, ажлын тайланг цаг тухай бүрт гаргах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.</p> <p>2.3 Албны бэлтгэлжилт, сургуулилтад тогтмол хамрагдаж, бие бялдар, оюуны чадамжаа тасралтгүй хөгжүүлэх.</p>   | Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.   | Г<br>Г<br>Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <p>3.1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам болон харуул хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам стандарт, цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын тушаал, шийдвэрийг удирдлага болгон үүрэг гүйцэтгэх.</p> <p>3.2. Нэгжид шинээр томилогдсон алба хаагч нарыг ажлын байранд сурган дадлагжуулах, дасан зохицуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, гэрээ байгуулан өдөр тутмын үйл ажиллагаа биечлэн зааварчилж, үр дүнг тооцуулах.</p>   | Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана. | Г<br>Г      |

|  |  |  |   |
|--|--|--|---|
|  | <b>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</b>  |  |   |
|  | 1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.  |  | Г |
|  | 2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах.   |  | Г |
|  | 3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.   |  | Г |
|  | 4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх. |  | Г |
|  | <b>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</b>   |  |   |
|  | 1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;                                     |  | Г |
|  | 2.Явцуу эрх ашиг сонирголоос татлгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.   |  | Г |


| <b>III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>   |  |   |
|---|--|---|
| <b>Боловсрол</b>  | Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой байх.  |   |
| <b>Мэргэжил</b>   |  |   |
| <b>Мэргэшил</b>   | Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх.   |   |
| <b>Туршлага</b>   |  |   |
| <b>Ур чадвар</b>  | Дүн шинжилгээ хийх   | -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах.<br>-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.  |
|   | Асуудал шийдвэрлэх   | -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих.   |
|   | Багаар ажиллах   | -Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах.<br>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох. |
|   | Бусад  |   |
| <b>IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b>  |  |   |
| <b>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</b><br>Алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга |  |   |
| <b>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</b><br>Батлагдсан орон тоо.   | <b>Бусад харилцах субъект:</b><br><b>Шууд харилцах байгууллага:</b><br>Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагын албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; |   |

|  |  |
|--|--|
|  | <b>Шууд бус харилцах байгууллага:</b><br>Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/. |
|--|--|

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:**

|   |  |
|---|--|
| <b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b> | <b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b> |
|---|--|

Албан тушаал:  
 ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
 ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

  
 Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Байгууллагын нэр:.....  
 Шийдвэрийн огноо:.....  
 Дугаар:.....

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр.  
 Дугаар: А/401

  
 ДАРГА,  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**Танилцсан:**

Албан тушаалтан: .....

20.. оны .... дугаар сарын ....-ны өдөр